АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн  Хотонт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/120/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор С.Оргил<br>Утас: 77665858<br>Цахим хаяг: Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 100

танай ______________-ны №______________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
А.БАЯНЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 963,988.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 817,493.2 мянган төгрөгийг зарцуулан, 154,703.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Архангай аймгийн Хотонт сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 2 үндсэн зорилтын 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 95.0 хувиар тайлагнасан байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 86,913,920.62 | 165,644,160.58 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 70,416,860.62 | 154,703,060.58 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 70,416,860.62 | 154,703,060.58 |
| 3121 | Төгрөг | 70,416,860.62 | 154,703,060.58 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 70,416,860.62 | 154,703,060.58 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 16,497,060.0 | 10,941,100.0 |
| 354 | Хангамжийн материал | 16,497,060.0 | 10,941,100.0 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 764,500.0 | 300,500.0 |
| 3542 | Аж ахуйн материал | 15,202,000.0 | 10,571,600.0 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 450,000,0 | - |
| 3546 | Хүнсний материал | 11,560,0 | - |
| 3547 | Бусад хангамжийн материал | 69,000,0 | 69,000,0 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 366,858,257.99 | 392,153,311.55 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 366,858,257.99 | 392,153,311.55 |
| 392 | Биет хөрөнгө | 352,798,257.99 | 378,093,311.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 352,598,498.59 | 352,598,498.59 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -42,411,858.09 | -50,409,747.15 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 28,409,673.0 | 43,153,473.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,024,014.65 | -7,901,413.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,667,648.60 | 58,890,916.73 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -17,161,719.46 | -18,958,446.45 |
| 39217 | Ном | 720,030.0 | 720,030.0 |
| 393 | Биет бус хөрөнгө | 14,060,000.0 | 14,060,000.0 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,060,000.0 | 14,060,000.0 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 453,772,178.61 | 557,797,472.13 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 453,772,178.61 | 557,797,472.13 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 453,772,178.61 | 557,797,472.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 95,141,920.0 | 95,141,920.0 |
| 51101 | Өмч: - төрийн | 95,141,920.0 | 95,141,920.0 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 308,367,279.54 | 412,392,573.06 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 308,367,279.54 | 308,367,279.54 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 104,025,293.52 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 453,772,178.61 | 557,797,472.13 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 676,006,460.62 | 936,246,568.13 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,967,000.0 | 34,467,168.13 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,967,000.0 | 34,467,168.13 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,967,000.0 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,967,000.0 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 34,467,168.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 670,039,460.62 | 901,779,400.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 580,427,600.0 | 868,895,700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 580,427,600.0 | 868,895,700.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 89,611,860.62 | 32,883,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 89,611,860.62 | 32,883,700.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 548,967,780.94 | 832,221,274.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 548,967,780.94 | 827,532,374.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 542,089,880.94 | 827,532,374.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 367,940,879.72 | 607,832,417.11 |
| 210101 | Үндсэн цалин | 273,037,006.31 | 393,509,921.32 |
| 210102 | Нэмэгдэл | 70,617,055.56 | 185,225,594.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,473,601.85 | 200,000.0 |
| 210104 | Урамшуулал | 15,813,216.0 | 28,896,901.78 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,646,874.84 | 75,387,107.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,175,667.10 | 51,649,178.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,775,121.09 | 6,060,117.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,957,442.75 | 4,086,500.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 702,390.57 | 2,702,709.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,036,253.33 | 10,888,602.02 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,745,000.0 | 27,916,100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,729,000.0 | 9,178,433.23 |
| 210302 | Түлш, халаалт | 12,880,818.76 | 18,008,746.77 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 135,181.24 | 728,920.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,298,100.0 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 4,298,100.0 | - |
| 2105 | Нормативт зардал | 65,407,945.0 | 69,046,435.0 |
| 210502 | Хоол, хүнс | 65,407,945.0 | 69,046,435.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.0 | 4,967,600.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.0 | 4,967,600.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 75,000.0 | 1,785,800.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 75,000.0 | 1,785,800.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,976,081.38 | 40,596,914.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,367,807.20 | 22,633,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,034,892.80 | 6,291,300.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,573,381.38 | 11,672,014.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,877,900.0 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,877,900.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,877,900.0 | - |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 4,688,900.0 |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 4,688,900.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 4,688,900.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 127,038,679.68 | 104,025,293.52 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 127,038,679.68 | 104,025,293.52 |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 670,039,460.62 | 901,779,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 670,039,460.62 | 901,779,400.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 580,427,600.0 | 868,895,700.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 580,427,600.0 | 868,895,700.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 89,611,860.62 | 32,883,700.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 89,611,860.62 | 32,883,700.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 540,773,459.56 | 814,993,300.04 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 540,773,459.56 | 814,993,300.04 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 533,895,559.56 | 814,993,300.04 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 376,303,106.36 | 607,520,969.26 |
| 210101 | Үндсэн цалин | 267,530,549.52 | 394,397,628.38 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 84,173,192.99 | 184,625,606.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,473,601.85 | 200,000.0 |
| 210104 | Урамшуулал | 16,125,762.0 | 28,297,734.58 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,284,648.20 | 75,698,555.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,813,441.65 | 50,185,372.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,742,756.37 | 6,336,512.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,989,803.09 | 3,175,447.52 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 702,395.78 | 3,329,100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,036,251.31 | 12,672,123.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,195,000.0 | 27,883,700.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,729,000.0 | 9,178,433.23 |
| 210302 | Түлш, халаалт | 12,926,000.0 | 17,976,346.77 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 540,000.0 | 728,920.0 |
| 2105 | Нормативт зардал | 65,420,005.0 | 69,034,875.0 |
| 210502 | Хоол, хүнс | 65,420,005.0 | 69,034,875.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.0 | 5,000,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.0 | 5,000,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,058,100.0 | 2,592,400.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,058,100.0 | 2,592,400.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,634,700.0 | 27,262,800.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,460,300.0 | 21,984,100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,174,400.0 | 5,278,700.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,877,900.0 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,877,900.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,877,900.0 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 129,266,001.06 | 86,786,099.96 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 2,499,900.0 |
| | Дотоод эх үүсвэрээр | - | 2,499,900.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 2,499,900.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | -2,499,900.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 129,266,001.26 | 84,286,199.96 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 70,416,860.62 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 70,416,860.62 | 154,703,060.58 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 95,141,920.0 | 50,262,979.07 | 308,367,279.54 | 453,772,178.61 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 104,025,293.52 | 104,025,293.52 |
| 10 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 95,141,920.0 | 50,262,979.07 | 412,392,573.06 | 557,797,472.13 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 963,988,100.00 | 817,493,200.04 | 146,494,899.96 | 84.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 963,988,100.00 | 817,493,200.04 | 146,494,899.96 | 84.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 963,988,100.00 | 817,493,200.04 | 146,494,899.96 | 84.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 730,994,600.00 | 607,520,969.26 | 123,473,630.74 | 83.11 |
| 210101 | Үндсэн цалин | 497,370,900.00 | 394,397,628.38 | 102,973,271.62 | 79.3 |
| 210102 | Нэмэгдэл | 222,154,700.00 | 184,625,606.30 | 37,529,093.70 | 83.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 200,000.00 | -200,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 11,469,000.00 | 28,297,734.58 | -16,828,734.58 | 246.73 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,280,700.00 | 75,698,555.78 | 8,582,144.22 | 89.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,312,600.00 | 50,185,372.70 | 7,127,227.30 | 87.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,740,600.00 | 6,336,512.52 | 404,087.48 | 94.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,371,200.00 | 3,175,447.52 | 195,752.48 | 94.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,371,200.00 | 3,329,100.00 | 42,100.00 | 98.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,485,100.00 | 12,672,123.04 | 812,976.96 | 93.97 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,883,700.00 | 27,883,700.00 | 0.00 | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,417,700.00 | 9,178,433.23 | 239,266.77 | 97.46 |
| 210302 | Түлш, халаалт | 17,926,000.00 | 17,976,346.77 | -50,346.77 | 100.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 540,000.00 | 728,920.00 | -188,920.00 | 134.99 |
| 2105 | Нормативт зардал | 80,820,800.00 | 69,034,875.00 | 11,785,925.00 | 85.42 |
| 210502 | Хоол, хүнс | 80,820,800.00 | 69,034,875.00 | 11,785,925.00 | 85.42 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,592,400.00 | 2,592,400.00 | 0.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,592,400.00 | 2,592,400.00 | 0.00 | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,415,900.00 | 29,762,700.00 | 2,653,200.00 | 91.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,637,300.00 | 21,984,100.00 | 2,653,200.00 | 89.23 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,778,600.00 | 7,778,600.00 | 0.00 | 100 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 963,988,100.00 | 901,779,400.00 | 62,208,700.00 | 93.55 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 868,895,700.00 | 868,895,700.00 | 0.00 | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 868,895,700.00 | 868,895,700.00 | 0.00 | 100 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 32,883,700.00 | 32,883,700.00 | 0.00 | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 32,883,700.00 | 32,883,700.00 | 0.00 | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 62,208,700.00 | 0 | 62,208,700.00 | |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 62,208,700.00 | 0 | 62,208,700.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 70,416,860.62 | -70,416,860.62 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 154,703,060.58 | -<br>154,703,060.58 | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар явцад 3,274.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн бүртгэлийг залруулан ажилласан болно.

Аудитаар залруулагдаагүй 6,433.4 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрч, 6,433.4 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, шилэн дансны зөрчилд 1 албан шаардлага, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илэрсэн зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,844.9 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 3.1. Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 4 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж, нийт 6,433.4 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь:_ Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:
3.2.1 Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.
_Илрүүлэлт:_

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: *Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүллээ.*

3.2.2 Нярвын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал

_Илрүүлэлт:_

Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Нягтлан бодох бүртгэлд нярвын программыг ашиглалтыг сайжруулж бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "… албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

*Зөвлөмжийн биелэлтийг 2025.10.20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлнэ үү.*

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Буруу ангилан бүртгэсэн | 1 | 3,274.0 | | | 1 | 3,274.0 | 1 | 3,274.0 | | | | |
| Дүн | 1 | 3,274.0 | | | 1 | 3,274.0 | 1 | 3,274.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 4 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж, алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна. | 1 | 6,433.36 | 1 | 6,433.36 | | | | | | | | |
| Шилэн данстай холбоотой | 1 | | | | 1 | | | | | | | |
| Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Нярвын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 4 | 6,433.36 | 1 | 6,433.36 | 1 | | 2 | | | | | |